



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/051/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2026 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Цахим актив аудит ХХК-ны аудитор: Д. Балжинням Утас:99435309 Цахим хаяг: Dbaljinnyam573@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....</b>	<b>5</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>9</b>
3.1 Зөвлөмж .....	10
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>11</b>
<b>5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл .....</b>	<b>11</b>

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

---

## **1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

---



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

Ховд аймгийн дарга Б.Дэлгэрбаяр № 211  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

АЛТАЙ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН  
ДАРГА Б.ДЭЛГЭРБАЯАР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын Соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Тайлант онд нийтийн бүжиг, концерт, түрээс зэрэг 35 үзвэр үйлчилгээ явуулж, давхардсан тоогоор 1530 үзэгчид хамруулан 1,097.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

0102050500

### Бусад асуудал

Үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд 2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 42 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийг эрх бүхий албан тушаалтан 91.2 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	30,513,775.96	25,369,446.56
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	30,513,775.96	25,369,446.56
35410	Бичиг хэргийн материал	1,752,742.56	1,418,542.56
35420	Аж ахуйн материал	23,593,044.00	18,792,954.00
35470	Бусад хангамжийн материал	5,167,950.00	5,157,950.00
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>30,513,775.96</b>	<b>25,369,446.56</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	671,418,857.49	632,064,673.27
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	667,793,857.49	628,589,673.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	597,751,031.08	597,751,031.08
39202	Хуримтлагдсан элэгдэл	-91,989,503.34	-103,620,376.50
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	148,747,218.00	148,086,518.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-43,954,013.62	-60,775,018.86
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	56,008,139.00	52,819,517.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,860,381.63	-18,884,755.45
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	6,330,210.00	451,600.00
39217	Ном	12,761,158.00	12,761,158.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	3,625,000.00	3,475,000.00
39301	Програм хангамж	1,750,000.00	1,750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-525,000.00	-675,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,400,000.00	2,400,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>671,418,857.49</b>	<b>632,064,673.27</b>
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>701,932,633.45</b>	<b>657,434,119.83</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	725,000.00	2,044,154.96
<b>413</b>	<b>Өглөг</b>	725,000.00	2,044,154.96
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	2,044,154.96
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>725,000.00</b>	<b>2,044,154.96</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	701,207,633.45	655,389,964.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	513,193,526.00	513,193,526.00
511002	Засгийн газрын оруулсан капитал орон нутгийн сан	513,193,526.00	513,193,526.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-58,332,054.79	-104,149,723.37
51210	Өмнөх үеийн үр дүн	-174,684,102.54	-58,332,054.79
51220	Тайлант үеийн үр дүн	116,352,047.75	-45,817,668.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	246,346,162.24	246,346,162.24
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>701,207,633.45</b>	<b>655,389,964.87</b>
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>701,932,633.45</b>	<b>657,434,119.83</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>218,819,312.48</b>	<b>212,558,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	183,303,712.48	176,253,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	183,303,712.48	176,253,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	35,515,600.00	36,305,400.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,515,600.00	36,305,400.00
<b>12</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО</b>	<b>136,619,313.00</b>	<b>1,097,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	136,619,313.00	1,097,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,432,500.00	1,097,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,432,500.00	1,097,500.00
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>355,438,625.48</b>	<b>213,656,100.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>239,086,577.73</b>	<b>253,462,159.98</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	201,187,059.45	251,975,258.39
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	117,891,652.92	151,028,711.13
210101	Үндсэн цалин	83,556,788.07	94,031,441.23
210102	Нэмэгдэл	29,205,904.85	48,028,583.59
210104	Урамшуулал	5,128,960.00	8,968,686.31
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	19,308,170.94	18,660,069.82
210201	Тэтгэврийн даатгал	9,321,228.80	12,761,547.02
210202	Тэтгэмжийн даатгал	1,075,859.15	1,463,692.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,179,923.09	731,846.35
210204	Ажилгүйдлийн даатгал	537,929.59	731,846.35
210205	Эрүүл мэндийн даатгал	2,193,230.31	2,971,137.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	27,738,562.43	34,573,595.42
210301	Гэрэл, цахилгаан	258,569.93	5,080,795.42
210302	Түлш, халаалт	25,237,806.50	26,468,400.00
210303	Цэвэр, бохир ус	2,242,186.00	3,024,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,354,781.62	8,285,306.40
210401	Бичиг хэрэг	752,100.00	1,094,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,180,890.00	350,039.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	623,211.62	844,477.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,614,490.00	5,996,290.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,150,000.00	2,435,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	150,000.00	835,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,600,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,300,000.00	750,000.00
210702	Дотоод албан томилолт	1,300,000.00	750,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,555,700.00	2,630,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,355,700.00	2,480,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	150,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	22,828,191.54	33,612,575.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,327,410.00	270,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,500,781.54	33,342,575.62
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	37,899,518.28	1,486,901.59
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	36,918,418.28	1,486,901.59
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,135,044.07	131,804.58
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	35,783,374.21	1,355,097.01
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>239,086,577.73</b>	<b>253,462,159.98</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>116,352,047.75</b>	<b>-39,806,059.98</b>

225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	6,011,608.60
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	0.00	6,011,608.60
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	0.00	-6,011,608.60
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>116,352,047.75</u></b>	<b><u>-45,817,668.58</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>218,819,312.48</b>	<b>212,558,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	183,303,712.48	176,253,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	183,303,712.48	176,253,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	35,515,600.00	36,305,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,515,600.00	36,305,400.00
<b>12</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО</b>	<b>1,432,500.00</b>	<b>1,097,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,432,500.00	1,097,500.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	1,432,500.00	1,097,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,432,500.00	1,097,500.00
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>220,251,812.48</u></b>	<b><u>213,656,100.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>223,397,406.19</b>	<b>213,656,100.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>184,797,887.91</b>	<b>212,169,198.41</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	117,891,652.92	148,984,556.17
210101	Үндсэн цалин	83,556,788.07	91,987,286.27
210102	Нэмэгдэл	29,205,904.85	48,028,583.59
210104	Урамшуулал	5,128,960.00	8,968,686.31
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	19,308,170.94	18,660,069.82
210201	Тэтгэврийн даатгал	9,321,228.80	12,761,547.02
210202	Тэтгэмжийн даатгал	1,075,859.15	1,463,692.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,179,923.09	731,846.35
210204	Ажилгүйдлийн даатгал	537,929.59	731,846.35
210205	Эрүүл мэндийн даатгал	2,193,230.31	2,971,137.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	27,738,562.43	34,573,595.42
210301	Гэрэл, цахилгаан	258,569.93	5,080,795.42
210302	Түлш, халаалт	25,237,806.50	26,468,400.00
210303	Цэвэр, бохир ус	2,242,186.00	3,024,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,726,301.62	2,019,677.00
210401	Бичиг хэрэг	374,000.00	580,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	350,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	623,211.62	844,477.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	245,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,861,200.00	3,265,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,861,200.00	1,665,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,600,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,300,000.00	750,000.00

210702	Дотоод албан томилолт	1,300,000.00	750,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,741,400.00</b>	<b>2,630,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,766,400.00	2,480,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	150,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,884,600.00</b>	<b>1,286,300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,884,600.00	1,286,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>38,599,518.28</b>	<b>1,486,901.59</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>36,918,418.28</b>	<b>1,486,901.59</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,135,044.07	131,804.58
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	35,783,374.21	1,355,097.01
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)</b>	<b><u>223,397,406.19</u></b>	<b><u>213,656,100.00</u></b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	513,193,526.00	246,346,162.24	-174,684,102.54	584,855,585.70
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	513,193,526.00	246,346,162.24	-174,684,102.54	584,855,585.70
C09	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	116,352,047.75	116,352,047.75
C10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	513,193,526.00	246,346,162.24	-58,332,054.79	701,207,633.45
C11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	513,193,526.00	246,346,162.24	-58,332,054.79	701,207,633.45
C13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	513,193,526.00	246,346,162.24	-58,332,054.79	701,207,633.45
C19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-45,817,668.58	-45,817,668.58
C20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	513,193,526.00	246,346,162.24	-104,149,723.37	655,389,964.87

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>12200</b>	<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>222,302,500.00</b>	<b>212,037,393.83</b>
122005	Төсвөөс санхүүжих	36,200,000.00	36,173,595.42
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	186,102,500.00	175,863,798.41
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>222,302,500.00</b>	<b>212,037,393.83</b>

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>222,302,500.00</b>	<b>212,037,393.83</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	222,302,500.00	212,037,393.83
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	153,766,400.00	148,984,556.17
210101	Үндсэн цалин	91,346,400.00	91,987,286.27
210102	Нэмэгдэл	50,240,400.00	48,028,583.59
210104	Урамшуулал	12,179,600.00	8,968,686.31
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	19,220,700.00	18,660,069.82
210201	Тэтгэврийн даатгал	13,070,100.00	12,761,547.02
210202	Тэтгэмжийн даатгал	1,537,700.00	1,463,692.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	768,800.00	731,846.35
210204	Ажилгүйдлийн даатгал	768,800.00	731,846.35
210205	Эрүүл мэндийн даатгал	3,075,300.00	2,971,137.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	34,705,400.00	34,441,790.84
210301	Гэрэл, цахилгаан	801,200.00	5,080,795.42
210302	Түлш, халаалт	30,879,800.00	26,336,595.42
210303	Цэвэр, бохир ус	3,024,400.00	3,024,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,360,000.00	2,019,677.00
210401	Бичиг хэрэг	360,000.00	580,000.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	350,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	844,477.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	245,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,600,000.00	3,265,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00	1,665,000.00
210604	Урсгал засвар	1,600,000.00	1,600,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,500,000.00	750,000.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	750,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,150,000.00	2,630,000.00
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	5,000,000.00	2,480,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	150,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,000,000.00	1,286,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	1,286,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>222,302,500.00</b>	<b>212,037,393.83</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,914.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, бүртгэх алдаа илрээгүй болно.

Залруулагдаагүй 7,914.1 мянган төгрөгийн 2 зөрчлөөс 2,044.1 мянган төгрөгийн материаллаг 1 зөрчил нь ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 7,914.1 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 2,044.1 мянган төгрөгийн давтан гаргахгүй байх 1 зөвлөмж, дараа тайлангийн хугацаанд залруулан бүртгэх 5,870.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

### **3.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **3.1.1 Өглөг данстай холбоотой асуудал**

Тайлант онд цалин хөлс, нэмэгдэл урамшуулал дансны илүү зарцуулалттай холбоотой ХАОАТ-ын 2,044.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэн ажилласан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх".16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;" 16.5.3 -д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэнтэй нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь: Өглөг үүсгэхгүй байх, дараа тайлангаар дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.*

#### **3.1.2. Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоогүй**

*Илрүүлэлт:* Үндсэн хөрөнгө орлого авахдаа санхүүгийн программд ашиглах жил оруулаагүйтэй холбоотой 3 нэр төрлийн 5,870.0 мянган төгрөгийн хөрөнгөд элэгдэл тооцоогүй зөрчил илэрлээ.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалын хавсралтын 10 дугаар зүйлийн 10.24-д "Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн элэгдүүлнэ", 10.26--д "Хөрөнгийн үлдэх өртөг, ашиглахаар тооцсон үлдсэн хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жил бүрийн эцэст хянаж, тооцооллын өөрчлөлтийг гүйцээх горимоор бүртгэнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Дараа тайлангийн хугацаанд дээрх хөрөнгүүдийн элэгдлийг орлогод хүлээн авсан онуудаас эхлэн нөхөж тооцон холбогдох данс бүртгэлд залруулга хийх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд цалин хөлс, нэмэгдэл урамшуулал дансны илүү зарцуулалттай холбоотой ХАОАТ-ын 2,044.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэн ажилласан зөрчил илэрлээ.	1	2,044.1					1	2,044.1
Үндсэн хөрөнгө орлого авахдаа санхүүгийн программд ашиглах жил оруулаагүйтэй холбоотой 3 нэр төрлийн 5,870.0 мянган төгрөгийн хөрөнгөд элэгдэл тооцоогүй зөрчил илэрлээ	1	5,870.0					1	5,870.0
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>7,914.1</b>					<b>2</b>	<b>7,914.1</b>

##### 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			